

МОНГОЛ ХЭЛНИЙ ӨНГӨ ЗААСАН ТЭМДЭГ НЭРЭЭР ИЛРЭХ  
ШУУД БУС НЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

Г.Даваажаргал

**Түлхүүр үг:** *тэмдэг нэр, сэтгэл хөдлөл, үнэлэмж, яруу илэрхийлэх зүй, шууд бус нэрлэлт*

Хүний танин мэдэхүй ямагт нарийсч, аливаа зүйлийн тухай бидний мэдлэг үргэлж хувьсаж байдагтай уялдаж тухайн үгээр тэмдэглэгдэж нэрлэгдсэн ухагдахууны агуулга багтаамж, цар хүрээ байнга өөрчлөгдөж байдаг. Үүнээс болж үгийн утга өөрчлөгдөнө. Ер нь хүн өөртөө тохиолдсон үзэгдэл юмсын адил төстэй ба ялгаатай шинж чанарыг тогтоон тодорхойлохдоо нэгийг нөгөөтэй жишин харьцуулах үйлдлийг хийдэг. Юмсын адил тал буюу төстэй шинж чанарыг олж тогтоох нь харьцуулах үйлийг тодорхой нэг зүйлд хамааруулан сэтгэж байгаа хэрэг юм. Бидний санахад энэ харьцууллын үр дүнд шууд бус нэрлэлт үүсч тэр нь хэлний янз бүрийн нэгжүүдээр илэрдэг бололтой.

Энэхүү өгүүллээрээ бид өнгө заасан тэмдэг нэр үүсмэл үг, задлаг хам бүтэц<sup>1</sup>, өвөрмөц хэлцийн бүрэлдэхүүндорж шууд бус нэрлэлт бүхий болох онцлогийг тодорхойлохоор зорилоо. Тэмдэг нэрээр тэмдэглэгдэж байгаа чанар шинж бодит ертөнцийн юмс үзэгдлээс салангид байдаггүй ба, шинж чанараас ангид юмс үзэгдэл гэж байхгүй юм. Улмаар, юм үзэгдэл, үйл хөдлөлтэй нягт холбоотой тэмдэг нэрээр баймж үнэлэмжийн зүйл илэрдэг гэж үздэг.

Задлаг (холбоо хэллэг) ба нийлэг (дан үг) аргаар бүтсэн нэгж шууд бус нэрлэлт бүхий болох шалтгаан, арга зарчмын тухайд товчхон авч үзье. Ертөнцийн юм үзэгдэл, үйл явдал, түүний шинж чанар болон хүний бүтээн бий болгосон аливаа зүйлийн нэг хэсэг нь жирийн буюу ерийн юм болж, нөгөө зарим нэг нь жирийн, ерийн бус харин хачин сонин, гажиг гайхалтай юм мэтээр тусч төсөөлөгддөг байна. Хэм хэмжээнээс гажиж хэтийдсэн зүйл болгон учир битүүлэг, ойлгомж муутай байх нь дамжиггүй учраас энэ нь хүний урьдаас мэддэг ямар зүйлтэй адил төстэй вэ гэдгийг эргэцүүлж бодоход хүргэнэ. Сэтгэцийн үйл ажиллагааны энэ суурин дээр л хэлний янз бүрийн адилтгал зүйрлэл үүсэх учиртай. Дан үг ба холбоо хэллэгээр илэрсэн шууд бус нэрлэлт нь агуулгын багтаамж, дүрслэн илэрхийлэх шинж зэргээрээ харилцан адилгүй байдаг хэдий ч, үүсэх арга зарчмын хувьд буюу утга шилжин нэрлэлт болж байгаагаараа, сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн байдлаараа, үнэлэмжийг агуулсан байдгаараа, яруу илэрхийлэх үүргээрээ адил байх юм.

Тухайн үг шууд бус нэрлэлт бүхий болно гэдэг нь харилцаа, адилсуулах холбоо, аналогийн буюу харьцуулал, үнэлэмж, сэтгэлийн хөдөлгөөн, яруу илэрхийлэх шинж гээд олон зүйлтэй холбоотой.

<sup>1</sup> Задлаг хам бүтэц гэдгийн дор, бүрэлдүүлж байгаа үгсийн заримынх нь үгийн сангийн утга хэвээрээ байж, заримынх нь үгийн сангийн утга шилжиж хэрэглэгдэх тогтвортой хэллэгийг бид оруулж байна

Эрдэмтэн Ж.Баянсан, Ш.Одонтог нар "...улаан" хэмээх нэг зүйлийн өнгө заасан үг өөр үгтэй холбогдож утга салаалсан жишээг ажиглая. Тэр айл улаан зам дээр байна гэвэл замаасаа хазайхгүй чигээрээ явсаар байтал шууд тааралдах утгатай. Улаан хэлэхгэвэл нууж хаалгүй ил тод хэлэх, улаан гараараа үзэлцэх гэвэл ямар нэгэн багаж зэвсэг хэрэглэхгүй биеэрээ тухайн үйл хэргийг үйлдэж, хийх, улаан нүүрээрээ учрах гэвэл ямар нэгэн хүнээр дамжуулж юм уу зуучлуулалгүй, захиа занаагаар ч биш, биеэрээ шуудхан л уулзах гэсэн шиг утга илэрхийлж байна. Дээрх жишээнээс үзэхэд эдгээр үгс тус бүр өөр зүйлийг зааж, ялгавартай утга илэрхийлж байгаа боловч тэдгээрийн хооронд ямар нэг утгын холбоо хамаарал, нийтлэг зүйл бас байгааг мэдэж болно. Тэр нийтлэг холбоо нь "улаан" гэсэн үг өнгө заасан үндсэн утгаараа үйлчлэхээс гадна бусад үгтэй холбогдож, харилцаанд орохдоо "шууд" гэсэн утга бүгдэд нь байгааг мэдэж болно. Ийнхүү утгын холбоо хамаарал байгаа учраас үгийн салаа утга нь тухайн хэлээр харилцагч хэн хүнд ойлгомжтой байдаг. Тиймгүй сэн бол ийм, тийм утга илэрхийлж байна гэдгийг хүмүүс ойлголцохгүйд хүрнэ. Өөр зарим нэгэн жишээ авъя: хар үс, хар цай, хар будаг, хар санаа, хар амиа бодох, хар бага нас, хар хүн, хар шөл, хар хэл ам, хар ухаан, хар ажил гэх зэрэгт орсон "хар" гэдэг үг өнгө заасан үндсэн утгаас гадна "уг юм холимог биш, дан, нэг төрлийн" зүйл болохыг заасан нийтлэг утгаараа холбогдож утга салаалсан байна. Эдгээр хэллэг тус бүр өөр өөр юм үзэгдлийг нэрлэн зааж байгаа боловч утгын нэгдлээрээ бас өөр хоорондоо холбоотой байгааг үзэж болно" (1996:169) гэсэн бол эрдэмтэн Ж.Төмөрцэрэн: "... Ногоон гэдэг өнгө зүс заасан тэмдгийн нэр нь ногоо гэдэг жинхэнэ нэрийг өнгө зүсийн төсөөтэй байдлаар утга шилжүүлэн хэрэглэснээс үүсчээ. Мөн цагаан гэдэг өнгө зүс заасан тэмдгийн нэр нь цагаа гэдэг жинхэнэ нэр үгээс утга шилжин хэрэглэгдсээр үүсэн хэрэг болно. Ийнхүү аль нэг юм үзэгдлийн адил төсөөтэй талыг баримтлан утга шилжүүлэн хэрэглэхийг зүйрлэл (метафора) гэдэг. Зүйрлэл нь нэлээд өргөн утгатай юм" (1974:31) гэжээ. Тэгвэл эрдэмтэн М.Базаррагчаа: "Бүхлийг хэсгээр төлөөлөн хураах нь нэршсэн тэмдэг нэр болон тооны нэр орон цагийн нэрээр илэрнэ. Энэ бол бүхлийг шинж (буюу хэсэг)-ээр илтгэж байгаа хэрэг юм. Жишээ нь: Хэрэв гай таарсан бол хээрийн хөх ч андуурч хазахгүй зэвхийнүүд юм хуна даа /Ц.До/ Толгойгоо арай чамай эргүүлбэл нүдний буланд түрүүчийн луглагар үзэгдэв /Ц.До/. Ээ, чи муу өлбөн цагаан! Өнөө чи хэдтэйдээ ийм үг хэлнэ вэ? /Д.На./ Эдгээр жишээнээс үзвэл, бүхлийг түүний хэсгээр төлөөлүүлэхээс гадна, уул юмын шинжээр цаад юмыг хэлэх нь буй. Жишээ нь: зэвхий царайтнууд, луглагар эр гэдгээс "зэвхийнүүд, луглагар" гэх мэт" (1996:23) гэжээ.

Энэ мэтчилэн, жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолдож, тэдгээрээр тэмдэглэгдэж байгаа хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг нэрлэх үл хувилах үг болох тэмдэг нэрийн илэрхийлэх утгын зарим онцлогийг судлаачид бүтээлдээ дурдсан байна. Ер нь, монгол хэлний зарим тэмдэг нэр нь өөрөө үнэлэмжийн утгатай болж байна уу эсвэл түүнд холбогдсон үг нь үнэлэмжийн утгатай болж байна уу гэдгийг авч үзвэл сонирхолтой зүйл бөгөөд ер үнэлэмж нь "сайн муу" гэсэн хоёр үндсэн утгатай байдаг. Жишээлбэл, сэтгэл гэх үгнээ хүйтэн, халуун гэсэн шинж заасан хоёр үгийг холбон хэрэглэхэд "хүйтэн сэтгэл" гэдэг нь сөрөг үнэлэмжийг, халуун сэтгэл гэдэг нь эерэг үнэлэмжийг агуулна. Тэгвэл юугаар нь авалцуулан холбож эерэг сөрөг үнэлэмжийн утгатай болгож байна вэ гэсэн асуулт урган гарч ирэх нь лавтай. Цагагаар хүйтэрч, хүйтэн болох үед хүнийбие даарч тохь тухгүй болдог ба ялангуяа тэнгэрийн царайг харж аж амьдралаа зохицуулж ирсэн малчин монголчуудын хувьд тэнгэр хүйтрэх нь төдий л сайн зүйл биш. Салхи исгэрч, цас шамарга шуурч тэнгэрийн муухай илрэн цаг агаар хүйтэн болдог шиг хүйтэн сэтгэлтэй хүн хажуугийн хүнээ өөрөөсөө холдуулж, түлхэж, хамт байх аргагүй болгодог аж. Яг л хүйтнээс хүн зугтдаг шиг. Хүйтэн гэх үг сэтгэл гэх хийсвэр утгатай үгтэй холбогдохдоо

ямагт сөрөг үнэлэмжийг илэрхийлж байна. Гэтэл зарим тэмдэг нэр ерөөс сөрөг үнэлэмжийг илэрхийлдэг. Хуйсгар зантай хүн гэвэл хүнд тааламжгүй сэтгэгдэл төрүүлдгийн учир нь цаг агаар хуйсарч тэнгэр муухайрахыг монгол хүн аятай таатай гэж үнэлдэггүйтэй холбоотой байна. Энэ мэтчилэнгээр хүний зан харилцаа, уур амьсгал жихүүн, зэврүүн, сэвэлзүүр байх нь сөрөг муугийн жишиг хэмжүүр болдог. Сэр сэр үлээсэн сэвэлзүүр салхи сайхан гэдэг ч “сэвэлзүүр” хэмээхүгийн “хөнгөн” гэх шинжийг онцолж, хүний буурь суурьтай биш, хуумгай хийсгэлэн занг илэрхийлжээ. Мөн, салхины тогтворгүй шинжийг муугийн жишиг хэмжүүр болгон, хүний ул суурьтай биш занг сайнгүй хэмээн үзэж энэ хоёрыг адилсуулан нэрлэлт үүсгэсэн аж.

Бидний ажиглан тогтоосноор судалгааны хэрэглэгдэхүүн болж буй өнгө заасан тэмдэг нэрс бусад үгтэй нийлж буюу өөрөөр хэлбэл, хэлцийн бүрэлдэхүүнд орохдоо ихэвчлэн сөрөг үнэлэмж илэрхийлж байгаа ба, түүнчлэн үйл үгийн язгуур болохдоо үндсэн утгаас адилтгажшууд бус нэрлэлт бүхий болсон байна.

Монгол хэлний өнгө заасан “хар” хэмээх тэмдэг нэр нь *хар мах, хар архи, хар ус, хар газар, хар хөлс, хар ажил, хар ажилчин, хар салхи, хар шуурга, хар хүч, хар муйхар, хар хүн, хар иргэн, хар бие, хар амь, хар толгой, хар шөл, хар амиа бод, хар бага наснаас, хар тавхай, хар санаа, хар дотор, хар хэл ам, хар дом, арван хар нүгэл, хар үйл, хар мөр, хар хэл, хар уур, хар алба, хар алхаа, хар аюул, хар элэгтэй, хар ухаан, хар үг, хар хэрүүл, хар мал (эзэнгүй мал), хар яриа, хар зуд, хар зураг, хар зүрх, хар чийг, хар феодал, хар яришиг, хар тэнхээ, хар төвөг, хар шүлс, хар гэр, хар нутаг, хар данс, хар дэлэн* гэх зэргээр утга шилжиж, хэлцийн бүрэлдэхүүнд орсон байна.

Утга шилжих нь нэрлэн тэмдэглэж байгаа тухайн зүйлийг аль нэг шинжээр нь адилтган зүйрлэх арга үйлээс үүдэлтэй байх нь түгээмэл. Иймд шилжсэн утгын зонхи нь тухайн үг хэллэгийн шууд утгаас дам хийсвэрлэж, адилтгах зүйрлэх аргаар үүссэн байдаг (Баянсан, 2016: 43). Цагааны эсрэг, хөө нүүрс зэргийн өнгө гэх үндсэн утгатай “хар” гэсэн тэмдэг нэрийн утга шилжсэн байдлыг ажиглавал:

*а. хар салхи, хар шуурга, хар санаа, хар дотор, хар мөр, хар хэл, хар уур, хар аюул, хар элэгтэй, хар үг, хар хэрүүл* зэрэг хар муу санаа, буруу үйлийг илэрхийлсэн;

*б. хар мах, хар цай, хар ус, хар газар, хар ажил, хар ажилчин, хар хүч, хар муйхар, хар шөл, хар алба, хар алхаа, хар ухаан, хар мал (эзэнгүй мал), хар зураг, хар хүн, хар иргэн, хар бие, хар амь, хар толгой, хар амиа бод, хар зүрх* зэрэг дан ганцаар, хольцгүй гэх санааг илэрхийлсэн байна.

*в. хар бороон дундуур, хар шуурганаар, хар өглөөгүүр, хар үүрээр, хар шөнөөр* гэх зэрэг жишээ нь тохиромжгүй цаг хугацаа, цаг агаарын таагүй нөхцөл байдлыг төвөгшөөх санааг илэрхийлсэн.

Эрдэмтэн Ж.Баянсан “Тухайн соёл-хэлтний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан танилтын онцлогоос шалтгаалж, юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарын тухай сэтгэлгээний тогтсон хэв шинж (стереотип), жишиг хэмжүүр (эталон) бий болдог байна. Сэтгэлгээний тогтсон хэв шинж, тогтсон хэмжүүр нь тухайн соёл хэлтэн юм үзэгдэл, үйл явдал, байдал нөхцөл, шинж чанарыг үнэлсэн үнэлэмж нь байдаг. Энэ үнэлэмж нь адилтгал зүйрлэлээр илэрнэ. Тэгвэл хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд багтаж, үгийн сангийн утгаараа ялангуяа юмын шинж, чанарыг заасан утгатай тэмдэг үгсээр энэхүү үнэлэмжийг шууд тэмдэглэн нэршүүлдэг гэж ойлгож болохгүй юм” (2016: 65) гэснийг бид энд онцолж байна.

Дээрх жишээний а хэсэгт цагаан өнгөтэй зүйл цэвэр байдаг ба тэр нь бохирдож хар болвол муухай гэж үзэх үнэлэмжийн утга нь онцолбор болсон байна. Улмаар, холбогдож буй үгийнхээ

шинж чанарыг тодотгож “хар” санаа, үйл нь “хэцүү, муу” байдаг гэсэн сөрөг үнэлэмжийг илэрхийлнэ. Ер нь ч хар өнгө хүний сэтгэл санаанд хүнд хүчир дарамтыг үүсгэдэг (Санжжав, 1990:113) нь судалгаагаар батлагдсан ажээ.

Адилтгасан нэрлэлтийг бүрдүүлж байгаа тухайн нэрийн утгыг хийсвэрлэхдээ түүгээр нэрлэгдсэн юмын бүх шинжийг биш, шинэ нэрлэлт үүсгэхэд давын өмнө зайлшгүй хэрэг болж байгаа аль нэг шинжийг л онцолж сонгодог.

б хэсэгт жишээлсэн *хар мах* (өөхгүй мах), *хар цай* (сүүгүй чанасан цай), *хар шөл* (махнаас өөр зүйл хийлгүйгээр буцалгасан шөл), *хар амь* (дан ганц өөрийн амь) гэх зэрэг хэлцэд “өөр зүйл оролцоогүй, дангаар, хольцоогүй” гэсэн нийтлэг утга холбогдож байна. Хар-өнгөгүй өнгө болохоор өнгө будагны хаан, тэр ч утгаар нь хамгийн сонгодог, нууцлаг сүрдэм,бусад өнгөө дарангуйлдаг, түүгээр ямар ч өнгийг дараад будчихдаг аж. Тэгвэл в хэсгийн жишээнд *цагаа олоогүй үйл явдал хүнд таагүй сэтгэгдэл төрүүлж, ирэх/явах цаг мундсан юм шиг ийм үед байхдаа яах вэ дээ* гэсэн баймж илэрч байна. *Хар төвөг болох, хар яришг удах* гэдэг жишээ ч энд холбогдоно.

*Хар хувцас, хар үс, хар хөмсөг, хар будаг, хар даавуу* гэвэл холбогдож байгаа нэрийн зүйлийнхээ өнгийг зааснаас биш “хар өнгөтэй байх нь муу муухай зүйл” гэсэн ямар нэг үнэлэмжийн утга байхгүй юм. Өөрөөр хэлбэл, өнгийг зааснаас биш, уг юмын аль нэг шинж чанарыг онцлоогүй. Харин *хар мөртэй, хар дотортой, хар элэгтэй* гэхэд “муу санаа, буруу үйлтэй” гэсэн үнэлэмжийн утгатай болно. Учир нь хэлц нэгжийн бүрэлдэхүүнд тус тэмдэг нэрийн утга нь хийсвэрлэж орохдоо “цагаан цайвар юмын хар (буртаг тоос) болох нь муухай” гэсэн шинж онцгойрч, улмаар “явдал үйл нь буртагтаж, санаа бодол нь урвуугаар эргэх байдал”-тай адилтгаж, ийм байх нь “муу зүйл” гэсэн үнэлэмж илэрхийлсэн байна.

Монголчууд бэлгэдлийн үүднээс хар өнгийг үл таашаан үздэг ба энэ тухай эрдэмтэн С.Дулам: “хар өнгө бол монгол утга соёлд домог зүй, бөө мөргөлийн зүүн зүгийн 44 тэнгэрийн өнгө зүс, түүнтэй холбоотой муу үйлийн өнгө болох учир буй. Энэ нь эн тэргүүнээ байгалийн сүр хүчний гарцаагүй илэрхийлэл, ертөнцийн мөхөл сүйрэл, түүний ёр тэмдэг нь болдог” (2001:11) гэж тэмдэглэсэн байна. Түүнээс гадна, “хар” гэх тэмдэг нэр оролцож бүтсэн хэлцүүдийг сайн-муу, сайхан-муухайн үнэлэмжийн үүднээс авч үзэхэд “муу”-г илэрхийлэх утга зонхилж байгаа нь дээрх жишээнүүдээс харагдана. Өөрийнх нь үзэмжид нийцтэй, зохистой юмандаа хүн дуртай байдаг бол түүнд нь эс нийцсэн юманд дургүй байдаг аж. Дуртай юм болгон нь эерэг үнэлэмжтэй, дургүй юм болгон нь сөрөг үнэлэмжтэй байх ёстой гэж үзвэл монголчуудын хувьд *хүний явдал үйл, бодол санаа энгийн жирийн байхаас уруудаж доройтвол муу* гэж үзээд түүнийгээ илэрхийлэхдээ “хар” гэсэн тэмдэг үгийн утгыг хийсвэрлэн шилжүүлжээ. Өөрөөр хэлбэл, хар өнгөний “хүнд” гэсэн шинж онцгойрон шууд бус нэрлэлтийг үүсгэсэн байна. Гэтэл, “хольцоогүй, дан” гэсэн утга бүхий *хар шөл, хар цай, хар ажил* зэрэг хэллэгт “муу, муухай” гэх утга ер холбогдолгүй байна. Ингэхлээр хүний өөрийнх нь амьдрах, оршихуйн хэрэгцээнд нь нийцэж, эс нийцэж байгаа бол ямар нэг юмын ерөнхий шинж нь эерэг, эсвэл сөрөг ч байж болох юм.

Монгол хэлэнд 1990-ээд оноос “харлах” гэх үг *харь газар визийн хугацаа хэтэрч хууль бусаар орогнон ажиллах* гэсэн шууд бус нэрлэлтийн утгаар идэвхтэй хэрэглэгдэн хэвшиж байна. Бидний санахад, харь оронд *харласан* хүнд тухайн орноор явах зорчих, эх орондоо чөлөөтэй ирэх, буцахгэх зэрэг эрх хаалттай байж, нуугдмал байдалтайгаар ажиллах ганцхан л гарц байдаг ажээ. Өөрөөр хэлбэл тэр хүнд “хар ажил хийх”-ээс өөр боломж олддоггүй ба дээрххолбоо хэллэг хэлний хэмнэх зарчмын үүднээс хураагдан *харлах* гэсэн үг үүссэн ба “дан” гэсэн утга илэрхийлэхийн дээр, хууль бус юм угаасаа муу, хэрэггүй байдаг гэх үнэлэмжийг

агуулжээ. “Хар” хэмээх үг нь харанхуй гэсэн үгийн язгуур болдгоос утгын гаргалгаа хийж үзвэл харанхуйд, гэрэл гэгээгүй хар юмны цаана юу байгаа нь мэдэгдэхгүй болдогтой адил “хар” хүмүүс нуугдмал, хаагдмал байдаг байна. Хэрэв визгүй ажиллаж амьдарч байгаа нь баригдвал эх орон руу нь албадан явуулж, тэр оронд ирэх эрхийг нь хязгаарлан “хар тамга” дардаг ажээ. Хар өнгөний илэрхийлэх дээрх мэтийн муушаал утгаас уламжлан “хар тамга” гэх холбоо хэллэг ярианы хэлэнд үүссэн бололтой.

“Улаан” гэсэн тэмдэг нэрийн үндсэн утгыг цусны өнгө мэт өнгө (Цэвэл, 1966:587) гэж тайлбарлажээ. *Улаан нүдтэй* (шунаг сувдаг, эд мөнгөнөөс өөрийг бодохоо байх), *улаан нүүрэн дээр нь* (өөрийг нь байхад, эзнийг нь байхад, дэргэд нь), *улаан нүүрээрээ* (халз биеэрээ), *улаан зам дээр нь* (яг өмнө нь ил), *улаан гараараа* (зөвхөн гар биеэр хийх), *улаан нүцгэн* (маш ядуу, биедээ өмссөн хувцасгүй; ус мод, өвсгүй буюу маш тачир газар), *улаан галзуу* (догшин ширүүн зан нь хэтэрсэн), *улаан дайрах* (айх эмээх, ичих зовохыг мэдэхгүй дайрах), *улаан худалч* (дандаа худлаа ярьдаг хүн), *улаан дээрэмчин* (айх ичихийг байсан хүн) гэсэн хэлцүүдэд “шууд” гэсэн нийтлэг утга холбогдохын зэрэгцээ, хэлэгч этгээдийн сэтгэл хөдлөл илэрч, улмаар сөрөг үнэлэмжийг илэрхийлсэн байна.

Эрдэмтэн Е.М.Вольф “Үнэлэмжийн үндсэнд  $A \ r \ B$  гэсэн томъёо байх ба  $A$  нь субъектийн үнэлэмжийг төлөөлж,  $B$  нь түүний объект болж, харин  $r$ -нь “сайн/муу” гэх утгыг хадгалсан үнэлэмжийн харьцаа болно. Ингэхлээр үнэлэмжийн гол элементүүд нь субъект, объект болон үнэлэмжийн өгүүлэхүүн (предикат) болж байна.  $A \ r \ B$  гэсэн хэлбэр дэх  $r$  өгүүлэхүүн нь үнэлэмжийн үндсийг тавьж, субъект, объектын хоорондын өвөрмөц үнэлэмжийн харьцааг тусгасан тэмдэг шинжээр тодорхойлогдоно. Эдгээр шинж тэмдгүүд нь “сэтгэл хөдлөл”, “үнэлэмж” юм. Тодруулбал, “сэтгэл хөдлөл” (үнэлэмж) гэдэг нь  $A \ r \ B$  гэсэн бүтэц дэх  $r$  гэсэн үндсэн тэмдэг бөгөөд “сайн/муу” гэсэн хоёр утгатай байдаг. Сэтгэл хөдлөлийн шалтгаан бол субъектийн сэтгэлийн хөдлөлөөр объектод өгөх үнэлэмж юм” (1985:37) гэснийг бид энд онцолж байна. Тухайлбал, “шуналтай” гэвэл ерийн үнэлэмж бүхий нэрлэлт болж, “улаан нүдтэй” гэх зэрэг нь сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий нэрлэлт болох юм.

Сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий тэдгээр үгс нь тухайн зүйлийн талаар өгүүлэгчийн хандлага, үнэлэмж ямар байгааг илүү нарийн тодорхой илэрхийлэх чадамжтай. *Цаадах чинь улаан худалч байсан одоо бүр улаан дээрэмчин болоо шив* гэхэд субъектээс объектод харьцах харьцааг онцолсон буюу өөрөөр хэлбэл сэтгэл хөдлөлийн үнэлэмжийг илэрхийлсэн байна. *Худалч хүн* гэвэл *худлаа ярих дуртай хүн* гэсэн ерийн утгыг илэрхийлэх бол *улаан худалч* гэдэг нь худалч худалч дотроо гойд илүү худалч, яахаас ч буцахгүй, юу ч гэж хэлэхээс сийхгүй хүн гэсэн утгыг илэрхийлснээрээ өгүүлэгч этгээдийн тухайн хүнд хандлага үнэлэмж ямар байгааг илэрхийлж, улмаар сонсогч этгээдийн сэтгэл хөдлөлд (тус жишээнд улаан худалч хүнээс холхон шиг явах хэрэгтэй гэсэн сэтгэгдэл сонсогч хүнд төрнө) нөлөөлөх юм. Тодруулбал, хэлэхүйн үзэгдэл болсон яруу илэрхийлэх шинж нь сэтгэл хөдлөл-сэдлийн үндсэн дээр гарч ирэх ба ярилцагчийн сэтгэл хөдлөлийн нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Яруу илэрхийлэх шинж бол харилцаанд оролцогч хүмүүсийн аль алинд нь хамаарах бөгөөд шууд бус нэрлэлтийн амин чухал зүйл болно. Хэлэгч этгээд, энгийн жирийн хэлж болох зүйлийг шууд бусаар хэлж байгаа нь уг юмыг үнэлсэн үнэлэмж, харьцаа хандлагаа харилцаж буй нөгөө хүндээ илэрхийлж, түүнд нөлөөлж адилсуулан, түүний сэтгэл хөдлөлийн байдал ямар байгааг тандах зорилгыг агуулж байна.

Бидний санахад, улаан өнгө нь хүний анхаарлыг татах шинжээрээ бусад өнгийг бодвол гойд илүү байдаг ба *улаан өнгөтэй юм бусдаас содон байдаг* гэсэн шинж онцгойрсон бололтой. Тиймдээ ч *улаан* гэх тэмдэг нэр орсон хэлцүүдэд эргэлзэж будилах зүйлгүй (*улаан зам дээр*),

муу талаараа бусдаас содон ялгарах (*улаан галзуу, улаан дайрах, улаан худалч, улаан дээрэмчин*) гэх шинжүүд илэрч байна.

Үүнчлэн *саарал өнгө* нь *үл мэдэг үнсэн цэнхэр, хар туяатай зэвхий цагаан өнгө* бөгөөд үүгээр илрэх шууд бус нэрлэлтийн утга нь “*чанар тааруу, муухан*” юм. Энэ нь “юмны цас мэт цагаан өнгөнөөс бууруу бол муу” гэж үзэх үнэлэмжтэй холбоотой бололтой. Ер нь монголчуудад чөтгөрийн зүйлийн хий биесийг дүрслэхдээ үнсэн саарал, орог саарал, зэгэл зэвхий өнгө зүсмийг илүү баримталдаг байна. Тэр нь нэг талаас тэдний оршдог орон газрын хүйтэн цэвдэг, орог бүрэг өнгө байдлыг дохиолохын хамт хүн зонд айдас жихүүдэс төрүүлэх үүрэг холбогдолтой. Шулмын өнгө зүс нь орог саарал, зэвхий шар байна (Дулам, 2001).

Тэгвэл *ногоон* гэх тэмдэг нэрээс үүсэл бүхий “нойлын ногоон”, “ногоорох” гэхэд *мах зэрэг идэх юмны өнгө хувилж гутан эвгүй үнэртэй болох* хэмээх анхны утгаас нь уламжлан хэтэрхий муу байх/сурах; гөлрөх, дүйнгэ болох, хэтэрхий их унтах, хэтэрглээ согтох, буюу “хэт муу, муухай байх” гэх шууд бус нэрлэлт үүсч байна.

“Хөх инээд хүрэх” гэсэн хэлцэд байгаа *хөх* гэх өнгө заасан үгэндхүйтэн хэмээх шинж онцолбор болж шууд бус нэрлэлтийн үүрэгтэй болсон байна. Хүн ямар нэгэн зүйлд дургүйцэх, түүнийг басамжлах, үл ойшоох, хүйтнээр хандах үедээ гаргах нэгэн төрлийн зан байдлыг дээрх хэлцээр илэрхийлдэг бол, *хөхөртлөө харуулах* (хэн нэгэн болон ямар нэгэн зүйлийг харуулдан хүлээх) *хөдөө хөхөрч, гадаа гандах* гэхэд байгаа “хөх” хэмээх язгуураас үүссэн үйл үгс нь “цөхрөх, ядрах” гэсэн утгын орчлоороо ойролцоо байна.

*Мэл гайхаж, цэл хөхрөх* (алмайрч гайхах, хөших) гэхэд сэтгэлийн хүчтэй цочролд орж симпатик мэдрэл идэвхжсэний нөлөөгөөр зүрхний үйл ажиллагаа ихэсч, төвийн судас өргөсөн, улмаар захын судсанд цус гүйцэд очихгүй болсны улмаас гарын үзүүр, нүүр зэрэг нь хөхөрч, хүйтэн болох үйл явцыг илэрхийлж байна. Ийнхүү, “хөх” өнгөний зааж байгаа шууд бус нэрлэлтийн утга нь сөрөг үнэлэмжийг илэрхийлж байна.

“Цагаан” гэсэн тэмдэг нэрийн үндсэн утгыг юмны цас мэт өнгө (Цэвэл, 1966:777) гэж тайлбарлажээ. Тус тэмдэг нэр задлаг хам бүтэц болон өвөрмөц хэлцийн бүрэлдэхүүнд орохдоо дараах байдлаар утга нь шилжсэн байна. Үүнд: бартаа саадгүй байх: цагаан газар (уул хад, мод чулуугүй, бартаагүй тэгш тал газар), цагаан бичиг (уншихад хялбар, сайхан бичиг), цагаан толгой (тухайн бичиг үсэгт сурах бүгд үсэг), цагаан үсэг (уншихад хялбар үсэг); ариун үнэнч, шударга: цагаан санаа (ариун санаа), цагаан үйл (ариун шударга үйл); цагаан хэл ам хүрэх (сүсэг бишрэлтэй хүмүүс, бусдын урьдчилж шагшин магтаж ярилцсанаас болж ажил хэрэг бүтэхээ болилоо гэх, өвчин хүрлээ гэж үзэх), цагаандаа гарах (ичих айхаа барах, хээгээ алдах; хүн чанараа алдах, яахаас ч буцахгүй болох) гэх мэт.

*Цагаан газар* гэх задлаг хам бүтцийн “цагаан” гэдэг үгийн *хар хорын зүйл байхгүй, сайхан* гэсэн үнэлэмжийн утгаас адилтган *бөртнийх бартаа байхгүй* хэмээн утгашилжсэн бол “газар” гэдэг нь үгийн сангийн үндсэн утгаа хадгалсан байна. Улмаар энэ хоёр үг нэгдэн *бартаа байхгүй цэлгэр газар* гэх утгыг илэрхийлж тогтвортой хэрэглэгдэн хэвшсэн аж. Тогтвортой гэдгийн учир нь цагаан гэх үгийг нь бор, ногоон гэх ч юм уу бусад үгээр сольж болохгүйтэй адил, газар гэдгийг нь гуу, жалга довцог гэх мэт үгээр сольж болохгүй юм. Хэрэв ингэвэл уул задлаг хам бүтцийн утга огт өөр болж, тогтвортой шинж үгүй болно. Түүнчлэн дээрх задлаг хам бүтэц дэх “цагаан” гэсэн үг юмны цас мэт өнгө хэмээх утгаар биш, “сайхан” гэх хамсмал утгатай болсон учраас яруу илэрхийлэх үүрэг бүхий болжээ.

“Манай нутагт Цагаан Долгор гэж нэг хүн байх” гэдэг жишээнд *цагаан* хэмээх үгээр хар хорын санаагүй, цайлган сэтгэлтэй хүний зан чанарыг илэрхийлсэн нь утгаа монголчууд “цагаан” өнгийг эхийн цагаан сүүтэй зүйрлэж сүү мэт цагаан сэтгэл гэх зэрэг адилтгал

үүсгэсэнтэй холбоотой. Мөн, цагаандаа гарах гэдэг хэлц байгаа нь нууж хаах зүйлгүй бүгд ил тод болох гэсэн утгатай бол *гэгээн цагаан өдөр* гэхэд харын эсрэг утгат өнгө, харанхуйн эсрэг утгат үгтэй утга ойролцоо байдлаараа хоршиж *ил тодорхой* гэх санааг илэрхийлжээ. Эдгээрээс, цагаан гэдэг өнгө заасан үгэнд “ил тод байх, далд битүүлэг зүйлгүй байх” гэсэн ерөнхий утга хадгалагдаж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, шууд бус нэрлэлт нь заавал үнэлэмжийн утгатай байна. Үнэлэмж нь юм, үзэгдэл, үйл явдал, үйл байдал, шинж чанарыг сайн/муу, сайхан/муухай, хэрэгтэй/хэрэггүй, ашигтай/ашиггүй, дуртай/дургүй, зэвүүцмээр/таашаамаар, баясмаар/гутмаар гэх мэт эсрэгцсэн айн солбицолд авч үздэгээрээ сэтгэц физиологи, танин мэдэхүйн онцгой сонин үзэгдлийн илэрхийлэл тайлал болдог (Баянсан, 2016:194). Өнгө заасан тэмдэг нэрийн утга хийсвэрлэн шилжиж, задлаг хам бүтэц, өвөрмөц хэлцийн бүрэлдэхүүнд орохдоо өнгө тус бүр (хар, улаан, хөх гэх мэт)-ийн аль нэг шинж нь онцгойрон шууд бус нэрлэлт бүтээх онцолбор болсон байх ба өөрөөр хэлбэл, адилтгасан нэрлэлтийг бүрдүүлж байгаа тухайн нэрийн утгыг хийсвэрлэхдээ түүгээр нэрлэгдсэн юмын бүх шинжийг биш, шинэ нэрлэлт үүсгэхэд давын өмнө зайлшгүй хэрэг болж байгаа аль нэг шинжийг л онцолж сонгодог. Хэлэгч этгээд, энгийн жирийн хэлж болох зүйлийг шууд бусаар хэлж байгаа нь уг юмыг үнэлсэн үнэлэмж, харьцаа хандлагаа харилцаж буй нөгөө хүндээ илэрхийлж, түүнд нөлөөлж адилсуулан, түүний сэтгэл хөдлөлийн байдал ямар байгааг тандах зорилгыг агуулж байна.

Шууд бус утга илэрхийлж байгаа эдгээр үгс өгүүлбэр, эхийн түвшинд хам орчноосоо шалтгаалан (дагавар авч язгуурын утгаас адилтган хэлцийн утгатай болох, бусад үгтэй нийлж хэлц үүсгэх) өнгө заасан үүргээсээ халихдаа хүний санаа бодол, үйл явдал, байдал төрхийн сайн сайхан биш шинжийг зааж, сөрөг үнэлэмжийг илэрхийлэх нь илүү түгээмэл байна. Түүнчлэн монголчуудын өнгийг бэлгэдэх сэтгэлгээ ч энд хамаатаж байна. Хүн гэгч өөрийн амьдралын хэвшилд сөргөөр нөлөөлж байгаа, ерийн хэм хэмжээнээс гажсан зүйлийг хэлний нэгжүүдээр илэрхийлж, түүнээс сургамж авах, сэргийлэх үүднээс хэлэлцдэг байх гэж санагдана.

## RESUME

Adjectives in indirect nomination refer characteristics of human thoughts and comment, and action and events and express negative value, depending on context and content in syntax and text (formed by adding suffix and having the idiom meaning comparing with root meaning or created by combination of other words) widening the function which determines color.

## Номзүй

**Базаррагчаа М.** *Ярианы хэлний ганцжисж утгажсан үгийн тухайд*. Монгол ярианы хэл. Уб., 1996.

**Баянсан Ж., Одонтөр Ш.** *Хэл шинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь*. Уб., 1996.

**Баянсан Ж.** *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб., 2016.

**Вольф Е.М.** *Функциональная семантика оценки*. М., 1985.

**Дулам С.** *Монгол бэлгэдэл зүй (Зүг чиг өнгөний бэлгэдэл)*. Уб., 2001.

**Өнөрбаян Ц.** *Орчин цагийн монгол хэлний үгзүй*. Уб., 2004.

**Пагва Т.** *Хэл шинжлэлийн удиртгал*. Ред. А.Лувсандэндэв. Уб., 1959.

**Санжжав Д.** *Сэтгэл судлал*. Уб., 1990.

**Төмөрцэрэн Ж.** *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Уб., 1974.